



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ**

2025 оны 02 сарын 20 өдөр

Дугаар 99

Улаанбаатар хот

**Үндсэн хөрөнгө акталж, данснаас
хасах зөвшөөрөл олгох тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 6.4.1, 6.4.2, 6.4.3, 6.4.4, дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Замын-Үүд чөлөөт бүсийн Захирагчийн ажлын албаны үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, нийт 59,829,000.00 (тавин есөн сая найман зуун хорин есөн мянга) төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2.Замын-Үүд чөлөөт бүсийн захирагч Д.Дамдинцэрэнд дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан хөрөнгийг акталж, данснаас хасах, сэлбэгээр ашиглах ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган “Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл удирдлага зохицуулалтын цахим систем”-д бүртгэх;

2.3.Арга хэмжээний биелэлтийг 2025 оны 2 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА


Б.ЦЭНГЭЛ

Д.НАРАНГЭРЭЛ

132000267

4-r huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2025 оны 02 дугаар сарын 20 ны өдрийн
99 дугаар тогтоолын хавсралт



ЗАМЫН-ҮҮД ЧӨЛӨӨТ БҮСИЙН ҮНДСЭН ХӨРӨНГӨД
БҮРТГЭЛТЭЙ АКТАЛЖ, ДАНСНААС ХАСАХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

д/д	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон он	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ (төгрөг)	Нийт балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл (төгрөг)
1	Трансформатор	10/18/2007	ш	1	59,829,000.00	59,829,000.00
Нийт дүн				1	59,829,000.00 (тавин есөн сая найман зуун хорин есөн мянга)	59,829,000.00 (тавин есөн сая найман зуун хорин есөн мянга)